



2013 оны 1 сарын 29
(9-р хэвлэл)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ Э-СОНИН

Мэдээний тойм:

- Хөрөнгийн зах зээлийн өдөрлөг амжилттай боллоо
- Финанс Монголиа 2013
- Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалт 2013 оны 02 сарын 25-ны өдөр эхэлнэ.
- Үнэт цаасны арилжааны мэдээ
- 2012 оны ХК-ийн ногдол ашиг тараалтын мэдээ

Хөрөнгийн зах зээлийн өдөрлөг амжилттай боллоо

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн санаачилгаар 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн байранд зохион байгуулагдсан “Хөрөнгийн зах зээлийн өдөрлөг” амжилттай болж өндөрлөлөө.

Энэхүү өдөрлөгт зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд болох “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, Санхүүгийн зохицуулах хороо, “ҮЦТТХТ” ХХК, Арилжаа эрхлэгчдийн холбоо, МХБ-ийн гишүүн брокер дилерийн компаниуд, төлбөр тооцоо гүйцэтгэгч банкууд зэрэг байгууллагуудын нийт 100 гаруй ажилтан албан хаагчид 500 гаруй ард иргэдийг хүлээн авч дотоодын хөрөнгийн зах зээлийн талаарх бүхий л төрлийн мэдээ, мэдээллийг өгөхийн сацуу нэг цэгийн үйлчилгээг үзүүлж үнэт цаасны болон төлбөр тооцооны дансуудыг нээж үнэт цаасны арилжаа, хувьцаат компаниуд болон гүшүүн пүүсүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээллээр ханган ажилласан байна.

Өдөрлөгийн үеэр 180 гаруй ирээдүйн хөрөнгө оруулагчид үнэт цаасны болон төлбөр тооцооны дансаа шинээр нээлгэсэн ба тус өдөрлөгөөс хойш үнэт цаасны данс шүүх болон нээх үйл ажиллагаа эрс идэвхижсэн үзүүлэлттэй байна.

“Финанс Монголиа 2013” Монголын санхүүгийн анхдугаар үзэсгэлэн, сургалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт, уул уурхай, үйлдвэрлэлийн салбарын үсрэнгүй хөгжлийг даган санхүү, хөрөнгийн зах зээл өдрөөс өдөрт боловсронгуй болж төрөл бүрийн санхүүгийн шийдлүүдийг санал болгох болсон бөгөөд тэр хэмжээгээрээ оролцогч талуудын тоо нэмэгдэж төрөлжсөөр байна.

Энэ бүх бүтээгдэхүүн үйлчилгээ, санхүүгийн шийдлүүд болон оролцогч талуудыг ард иргэдэд ойртуулах зорилгоор “Дэлхийн Худалдааны Төв Улаанбаатар” ТББ, Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон “Мишээл групп” ХХК нар хамтран “Финанс Монголиа 2013” Монголын санхүүгийн анхдугаар үзэсгэлэн, сургалтыг хоёрдугаар сарын 22-24-ний өдрүүдэд “Мишээл Экспо танхим”-д зохион байгуулах гэж байна.

Энэхүү үзэсгэлэнд брокер, дилерийн компаниуд, арилжааны банкууд, даатгалын компаниуд, аудитын байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод, банк бус санхүүгийн байгууллагууд болон хөрөнгийн үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллагууд зэрэг Хөрөнгө, санхүүгийн салбарын мэргэжлийн оролцогчид болох 90 гаруй байгууллага оролцож тус тусын бүтээгдэхүүн үйлчилгээ санхүүгийн шийдлүүдийг танилцуулахын зэрэгцээ үнэгүй сургалт семинарыг зохион байгуулах юм байна.

Дэлгэрэнгүй: www.financemongolia.com-с авна уу.

Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалт 2013 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эхэлнэ.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.mse.mn хаягаар эсвэл 11-313747 утсаар холбогдож авна уу.

TOP-20 индексийн үзүүлэлт



2013 оны 1 дүгээр сарын 2-ноос 2013 оны 1 дүгээр сарын 28-ны хооронд нийт 20 удаагийн арилжаа явагдаж, 79 компанийн 4,1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 8,4 сая ширхэг хувьцаа арилжсан байна.

Тус хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь “Монинжбар” ХК /1.556,1 сая.төг/, “Дархан нэхий” ХК /1.305,9 сая.төг/ “Ремикон” ХК /366,56 сая.төг/ байсан байна.

Үнэт цаасны арилжааны мэдээ

Хувьцааны арилжаа: 1 дүгээр сарын 2-ноос 28-ны хооронд:

Арилжаа явагдсан өдөр	20
Арилжигдсан ширхэг	8,4 сая
Арилжигдсан дүн	4,1 тэрбум.төг
Арилжигдсан компанийн тоо	79
Нийт хийгдсэн хэлцлийн тоо	1466
Өдрийн дундаж	207,3 сая.төг

Хамгийн их өсөлттэй:

Цагдуултай /HAM/ +74,61%
Нако түлш /NKT/ +43,24%
Бөхөг /BHG/ +36,72%

бууралттай:

Шивээ овоо /SHV/ -17,17%
Азиа пасифик пропертиес /APP/ -15,15%
Адуун чулуу /ADL/ -15,76%

Зах зээлийн үнэлгээ: 1.805,93 тэрбум.төг
1,3 тэрбум ам.доллар

TOP-20 индексийн өөрчлөлт: 18.165,31 / +0.3%



2012 ОНЫ НОГДОЛ АШГИЙН СУДАЛГАА

д/д	КОМПАНИЙН НЭР	КОД	НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ /ТӨГ/	НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО ШИРХЭГ	НОГДОЛ АШГИЙН НИЙТ ДҮН /ТӨГ/	*ТАРААХ ХЭЛБЭР	НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ШИЙДВЭР
1	Ремикон	530	5	78,679,464	393,397,320	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.02.13-ны өдрийн 14/1 тоот тогтоол.
2	АПУ	90	60	74,287,700	4,457,262,000	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.02.17-ны өдрийн 7 тоот тогтоол
3	Махимпекс	208	60	3,800,721	228,043,260	ХК	ТУЗ-ийн 2012.02.17-ны өдрийн 01 тоот тогтоол
4	Эрдэнэт суврага	377	5	35,591	177,955	ҮЦТТХТ	ХЭХ-ын 2012.02.17-ны өдрийн 06 тоот тогтоол
5	Талх чихэр	22	90	1,023,703	92,133,270	ХК	ТУЗ-ийн 2012.02.20-ны өдрийн 02 тоот тогтоол
6	Ган хийц	234	150	242,464	36,369,600	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.03.02-ны өдрийн 03 тоот тогтоол
7	Тахь-ко	44	56	1,189,983	66,639,048	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.03.07-ны өдрийн 05 тоот тогтоол
8	Адуунчулуун	461	45	3,151,304	141,808,680	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.03.15-ны өдрийн 02 тоот тогтоол
9	Хялганат	114	148.32	10,113	1,499,960	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.03.13-ны өдрийн 06 тоот тогтоол
10	Улаанбаатар ЗБ	3	300	335,297	100,589,100	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.03.15-ны өдрийн 01 тоот тогтоол
11	Баянгол ЗБ	13	350	423,065	148,072,750	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.25-ны өдрийн тоот тогтоол
12	Дорнод худалдаа	311	50	73,969	3,698,450	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.06-ны өдрийн 06 тоот тогтоол
13	Монинжбар	25	2	15,869,233	31,738,466	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.19-ны өдрийн 4 тоот тогтоол
14	Байгууламж	24	200	50,922	10,184,400	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.02.07-ны өдрийн 5 тоот тогтоол
15	Тулга	5	60	131,620	7,897,200	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.30-ны өдрийн 5 тоот тогтоол
16	Ээрмэл	191	31.74	3,479,320	110,433,617	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.07-ны өдрийн 07/12 тоот тогтоол
17	Таван толгой	458	1368	52,665,200	72,045,993,600	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.30-ны өдрийн 3 тоот тогтоол
18	Женко тур бюро	521	1.5	100,000,000	150,000,000	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.02.03-ны өдрийн 8 тоот тогтоол
19	Хүрд	8	138	135,266	18,666,708	ХК	ТУЗ-ийн 2012.02.15-ны өдрийн 1 тоот тогтоол
20	Талын гал	464	10	694,264	6,942,640	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.26-ны өдрийн 6 тоот тогтоол
21	Могойн гол	444	5	829,622	4,148,110	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.25-ны өдрийн 7 тоот тогтоол
22	Тээвэр дархан	217	400	163,349	65,339,600	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.30-ны өдрийн 2 тоот тогтоол
23	Монгол алт	68	150	265,852	39,877,800	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.30-ны өдрийн 2 тоот тогтоол
24	Газар сүлжмэл	34	2835.63	65,362	185,342,448	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.05.18-ны өдрийн 2 тоот тогтоол
25	Гутал	88	120	1,618,684	194,242,080	ХК	ТУЗ-ийн 2012.06.18-ны өдрийн 8 тоот тогтоол
26	Говь	354	100	780,113	78,011,250	ХК ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.17-ны өдрийн 5 тоот тогтоол
27	Зоос гоёл	450	18	3,754,944	67,588,992	ХК	ТУЗ-ийн 2012.04.27-ны өдрийн тоот тогтоол
28	Материал импекс	379	50	1,368,206	68,410,300	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.18-ны өдрийн 4 тоот тогтоол
29	Монголын цахилгаан холбоо	209	13.28	25,870,276	343,557,265	ҮЦТТХТ	ТУЗ-ийн 2012.04.16-ны өдрийн 2 тоот тогтоол
НИЙТ				370,995,607	79,098,065,869	-	